

## **2.4. Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийн хэрэгжилт**

Аймгийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийн үндсэн бүтэц агуулгыг Монгол Улсын Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөртэй уялдуулан тодорхойлсон бөгөөд нийт 4 бүлэгт 219 зорилт тавьж, хэрэгжүүлэх төлөвлөгөөг 564 зүйлтэйгээр боловсруулан аймгийн ИТХ-аар хэлэлцүүлэн батлуулан ажиллаж байна.

Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийн биелэлтээс салбараар нь авч үзвэл Эрүүл мэндийн салбар 65.4%, Боловсрол соёлын салбар 62.1%, Хөдөлмөр эрхлэлтийн бодлогын хэрэгжилт 67.8%, Нийгмийн хамгааллын талаарх зорилт 65.5%, Хүн ам зүйн талаарх бодлогын хэрэгжилт 74.6%, Төсөв санхүү, эдийн засаг, татварын бодлогын хэрэгжилт 71.2%, Үйлдвэржүүлэх бодлогын хэрэгжилт 60.6%, Хөдөө аж ахуй, хүнсний аюулгүй байдлын бодлогын хэрэгжилт 64.0%, Дэд бүтэц, хот байгуулалтын бодлогын хэрэгжилт 61.5%, Байгаль орчин аялал жуулчлалын талаар баримтлах бодлогын хэрэгжилт 69.4%, Эрх зүйн бодлогыг хэрэгжүүлэх, гэмт хэрэгтэй тэмцэх бодлогын хэрэгжилт 66.5%, Иргэний нийгэм, төрийн удирдлага, гадаад бодлогын хэрэгжилт 64.8%, Орон нутаг, хил хамгалал, гамшгаас сэргийлэх бодлогын хэрэгжилт 62.9 хувь тус тус биелэсэн байна.

Аймгийн ИТХ-ын VIII хуралдаанаар Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийн биелэлтийг 65.8 хувийн биелэлттэйгээр **“Хангалттай”** гэж дүгнэлээ.